



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2024.02.21 № 56

танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН
ШУУД ЗАХИРАГЧ Ч.ОТГОНСҮРЭН
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тайланг аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн асуудлын бүртгэл, төлбөрийн акт, зөвлөмжийн хамт хүргүүлж байна.

Төсөв, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах, төлбөрийн актыг хугацаанд нь хэрэгжүүлж, аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны дотор гаргаж ирүүлэхийг зөвлөж байна.

Хавсралт..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



D:\2024\Alban toot.doc
008030029

Мал эмнэлгийн газрын 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тайланг аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн асуудлын бүртгэл, төлбөрийн акт, зөвлөмжийн хамт хүргүүлж байна.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2024/10/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2024 он	Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК Захирал: Ж.Баяртуул Утас: 99066015, Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....
 - ..
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗАР”-ЫН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ч.ОТГОНСҮРЭН ТАНАА

2024.02.22 № 02

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020270

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>212,579,568.23</u>	<u>259,549,019.07</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	8,300,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	8,300,000.00
31218	Ахмадын сан харилцах		8,300,000.00
33	АВЛАГА	-	448,884.91
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	448,884.91
35	БАРАА МАТЕРИАЛ	212,579,568.23	250,800,134.16
351	Түүхий эд материал	189,128,387.86	223,588,823.79
35130	Эм боох материал	189,128,387.86	223,588,823.79
354	Хангамжийн материал	23,451,180.37	27,211,310.37
35410	Бичиг хэргийн материал	1,201,650.00	1,862,580.00
35420	Аж ахуйн материал	4,669,200.00	5,385,900.00
35450	Барилгын засварын материал	922,000.00	922,000.00
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	16,658,330.37	19,040,830.37
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>168,863,260.55</u>	<u>127,385,480.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	168,863,260.55	127,385,480.58
391	Газар		
392	Биет хөрөнгө	101,533,815.86	60,185,480.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,350,400.00	14,350,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,632,351.26)	(3,349,871.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	167,308,200.67	167,308,200.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	(122,458,211.30)	(141,941,819.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	86,180,502.76	88,482,102.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,362,058.71)	(66,959,531.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,931,500.00	18,817,813.17
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,784,166.30)	(16,521,813.43)
393	Биет бус хөрөнгө	67,329,444.69	67,200,000.00
39301	Програм хангамж	2,430,000.00	2,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,300,555.31)	(2,430,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,200,000.00	67,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>381,442,828.78</u>	<u>386,934,499.65</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,811,265.00</u>	<u>30,698.91</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,811,265.00	30,698.91
413	Өглөг	6,811,265.00	30,698.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	30,698.91
4136	Бусад өглөг	6,811,265.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	6,811,265.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>374,631,563.78</u>	<u>386,903,800.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	374,631,563.78	386,903,800.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	67,200,000.00	67,200,000.00
51101	Өмч: - төрийн	67,200,000.00	67,200,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	305,201,873.97	317,474,110.93
51210	Өмнөх үеийн үр дүн	356,146,747.25	305,201,873.97
51220	Тайлант үеийн үр дүн	(50,944,873.28)	12,272,236.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,229,689.81	2,229,689.81

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	381,442,828.78	386,934,499.65
---	--	----------------	----------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	430,474,963.47	797,496,003.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,098,134.47	116,158,833.82
120	Нийтлэг татварын бус орлого	98,098,134.47	110,591,133.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	98,098,134.47	110,483,133.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,921,105.00	1,937,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	54,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	95,177,029.47	108,491,733.82
120005	Түрээсийн орлого	-	108,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	5,567,700.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,567,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	332,376,829.00	681,337,170.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	312,433,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	312,433,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,943,829.00	681,337,170.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,015,989.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,927,840.00	681,337,170.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	481,419,836.75	785,223,766.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	481,419,836.75	785,223,766.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,925,847.52	665,052,300.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,207,095.73	242,218,990.49
210101	Үндсэн цалин	133,153,380.73	145,846,088.57
210102	Нэмэгдэл	23,335,910.00	61,629,095.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,375,500.00	9,685,451.00
210104	Урамшуулал	8,342,305.00	25,058,355.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,829,502.23	34,155,586.42
210201	Тэтгэврийн даатгал	16,002,776.09	24,789,238.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,985,500.79	2,408,093.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,983,364.80	2,807,369.21
210204	Ажилгүйдлийн даатгал	392,492.48	226,028.91
210205	Эрүүл мэндийн даатгал	3,465,368.07	3,924,857.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,978,007.71	23,715,133.00
210301	Гэрэл, цахилгаан	823,287.71	933,840.74
210302	Түлш, халаалт	6,433,687.00	5,878,430.26
210303	Цэвэр, бохир ус	321,033.00	502,862.00
210304	Байрны түрээс	14,400,000.00	16,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,915,719.27	18,683,295.26
210401	Бичиг хэрэг	2,550,840.00	2,214,002.00
210402	Тээвэр, шатахуун	7,297,479.00	10,297,608.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,164,430.00	1,048,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	87,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,864,200.00	2,194,080.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	226,700.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	2,842,105.26

210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	7,712,070.28	-
2105	Нормативт зардал	92,792,408.96	72,782,683.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,598,938.96	72,782,683.81
210502	Хоол, хүнс	193,470.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	867,000.00	14,890,226.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	401,100.00
210604	Урсгал засвар	867,000.00	14,489,126.00
2107	Томилолт, зочны зардал	10,316,000.00	10,106,000.00
210702	Дотоод албан томилолт	10,316,000.00	10,106,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,584,170.00	203,703,047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,632,000.00	196,318,347.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	299,100.00	1,860,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,975.00	381,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,895.00	113,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	40,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,940,000.00	4,988,800.00
210807	Газрын төлбөр	67,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,435,943.62	44,797,338.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,956,555.00	8,575.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,479,388.62	44,788,763.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,493,989.23	120,171,466.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,112,889.00	15,225,428.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,404,057.00	12,839,228.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,708,832.00	2,386,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,381,100.23	104,946,038.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,381,100.23	104,946,038.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(50,944,873.28)	12,272,236.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	335,297,934.00	689,004,270.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,921,105.00	7,518,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,921,105.00	1,950,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,921,105.00	1,842,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,921,105.00	1,788,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	54,000.00
120005	Түрээсийн орлого	-	108,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	5,567,700.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,567,700.00
124	Зээлийн орлого	-	-
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	332,376,829.00	681,486,170.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	312,433,000.00	681,486,170.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	312,433,000.00	681,486,170.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,943,829.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,015,989.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,927,840.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	330,956,034.00	677,854,270.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	330,956,034.00	677,854,270.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	286,462,044.77	557,682,803.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	175,962,140.00	242,637,176.49
210101	Үндсэн цалин	134,906,269.00	146,264,274.57
210102	Нэмэгдэл	22,103,825.00	61,629,095.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,296,854.00	9,685,451.00
210104	Урамшуулал	7,655,192.00	25,058,355.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,074,457.96	34,155,586.42
210201	Тэтгэврийн даатгал	16,452,994.84	24,789,238.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,751,524.39	2,408,093.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,657,146.33	2,807,369.21
210204	Ажилгүйдлийн даатгал	322,249.28	226,028.91
210205	Эрүүл мэндийн даатгал	3,890,543.12	3,924,857.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,978,007.71	23,715,133.00
210301	Гэрэл, цахилгаан	823,287.71	933,840.74
210302	Түлш, халаалт	6,372,688.00	5,878,430.26
210303	Цэвэр, бохир ус	382,032.00	502,862.00
210304	Байрны түрээс	14,400,000.00	16,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,023,579.00	15,373,688.00
210401	Бичиг хэрэг	2,176,150.00	1,732,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,099,629.00	10,297,608.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,164,430.00	1,063,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	87,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	483,370.00	2,193,180.00
2105	Нормативт зардал	11,332,400.10	310,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,332,400.10	310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,148,300.00	20,724,333.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,900.00	1,208,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,000,000.00
210604	Урсгал засвар	3,118,400.00	14,515,733.00
2107	Томилолт, зочны зардал	10,316,000.00	10,106,000.00
210702	Дотоод албан томилолт	10,316,000.00	10,106,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,602,905.00	210,652,312.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,850,735.00	203,267,612.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	299,100.00	1,860,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,975.00	381,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,895.00	113,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	40,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,000.00	4,988,800.00

210807	Газрын төлбөр	67,200.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,255.00	8,575.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,255.00	8,575.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,493,989.23	120,171,466.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,112,889.00	15,225,428.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,404,057.00	12,839,228.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,708,832.00	2,386,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,381,100.23	104,946,038.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,381,100.23	104,946,038.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,341,900.00</u>	<u>11,150,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,341,900.00	2,850,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,341,900.00	2,850,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,341,900.00	2,850,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,341,900.00	2,850,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,341,900.00)</u>	<u>(2,850,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	8,300,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,300,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	67,200,000.00	2,229,689.81	356,146,747.25	425,576,437.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	67,200,000.00	2,229,689.81	356,146,747.25	425,576,437.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Тайлант үеийн үр дүн			-50,944,873.28	-50,944,873.28
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	67,200,000.00	2,229,689.81	305,201,873.97	374,631,563.78
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	67,200,000.00	2,229,689.81	305,201,873.97	374,631,563.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	67,200,000.00	2,229,689.81	305,201,873.97	374,631,563.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			12,272,236.96	12,272,236.96

2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	67,200,000.00	2,229,689.81	317,474,110.93	386,903,800.74
---	---------------	--------------	----------------	----------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	478,267,800.00	364,784,811.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,267,800.00	364,784,811.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,024,300.00	349,559,383.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,217,700.00	237,688,110.49
210101	Үндсэн цалин	214,160,500.00	146,264,274.57
210102	Нэмэгдэл	79,535,700.00	56,680,029.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,182,000.00	9,685,451.00
210104	Урамшуулал	29,339,500.00	25,058,355.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,051,000.00	33,536,952.42
210201	Тэтгэврийн даатгал	29,835,300.00	24,170,604.15
210202	Тэтгэмжийн даатгал	3,510,000.00	2,408,093.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,808,100.00	2,807,369.21
210204	Ажилгүйдлийн даатгал	701,900.00	226,028.91
210205	Эрүүл мэндийн даатгал	7,195,700.00	3,924,857.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,936,100.00	23,715,133.00
210301	Гэрэл, цахилгаан	943,800.00	933,840.74
210302	Түлш, халаалт	6,086,100.00	5,878,430.26
210303	Цэвэр, бохир ус	506,200.00	502,862.00
210304	Байрны түрээс	16,400,000.00	16,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,196,300.00	11,093,380.00
210401	Бичиг хэрэг	1,732,400.00	1,732,400.00
210402	Тээвэр, шатахуун	6,017,300.00	6,017,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,068,000.00	1,063,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргчдийн устгал, ариутгал	87,200.00	87,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,291,400.00	2,193,180.00
2105	Нормативт зардал	310,000.00	310,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	310,000.00	310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,574,400.00	23,574,333.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,058,600.00	4,058,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	14,515,800.00	14,515,733.00
2107	Томилолт, зочны зардал	5,745,000.00	5,745,000.00
210702	Дотоод албан томилолт	5,745,000.00	5,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,960,600.00	13,887,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,503,200.00	6,503,200.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,860,900.00	1,860,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	381,000.00	381,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,400.00	113,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,700.00	40,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,004,700.00	4,988,800.00
210807	Газрын төлбөр	50,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,200.00	8,575.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,200.00	8,575.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,243,500.00	15,225,428.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,243,500.00	15,225,428.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,839,300.00	12,839,228.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,404,200.00	2,386,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	475,767,800.00	370,985,411.91
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	475,767,800.00	370,985,411.91
122005	Орон нутгийн төсвөөс	475,767,800.00	370,985,411.91
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,500,000.00	2,099,400.00

2.4 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	210,973,420.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,973,420.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210,973,420.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,949,066.00
210102	Нэмэгдэл	4,949,066.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	618,634.00
210201	Тэтгэврийн даатгал	618,634.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,280,308.00
210402	Тээвэр, шатахуун	4,280,308.00
2107	Томилолт, зочны зардал	4,361,000.00
210702	Дотоод албан томилолт	4,361,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,764,412.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,764,412.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	205,569,370.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	205,569,370.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	205,569,370.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мал эмнэлгийн газар нь "Төрөөс мал эмнэлгийн талаар хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг орон нутагт зөв зохион байгуулж хэрэгжүүлэх замаар мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгч өвчинтэй тэмцэж халдварт өвчингүй тайван газар нутгийг дотооддоо баталгаажуулан хадгалах, малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шууд нөлөөлөх мал эмнэлгийн ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж зах зээлд нийлүүлэгдэх хүнсний аюулгүй байдлыг хангах, боловсруулах үйлдвэрт нийлүүлэгдэх түүхий эдийн чанарт ахиц дэвшил гаргах, малчин өрхийн санхүүгийн чадавхыг сайжруулахад бодитой үр нөлөө үзүүлэхэд оршино" гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/359 тушаалаар 21 орон тоо баталж, 13 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж, 8 орон тоо дутуу ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/359 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажилладаг байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь зарим холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 160,341.5 мянган төгрөгөөр буюу 28.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мян төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	8,300.00	8,300.00
Авлага	-	448.90	448.90
Урьдчилгаа			-
Бараа материал	212,579.60	250,800.10	38,220.50
Үндсэн хөрөнгө	168,863.30	127,385.50	(41,477.80)
Нийт хөрөнгө	381,442.90	386,934.50	5,491.60
Өр төлбөр	6,811.30	30.70	(6,780.60)
Заасгийн газрын хувь оролцоо/ Эздийн өмч/	374,631.60	386,903.80	12,272.20
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө /өмчийн дүн/	381,442.90	386,934.50	5,491.60

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна: Үүнд:

- Мөнгөн хөрөнгө нь өмнөх оноос нэмэгдсэн байгаа нь тайлант оны ахмадын сан үүсгэсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэл тайлант онд малын цэцэг мялзан ~~галзуу~~ гэсэн өвчний дэгдэлт өндөр байсан тул халдварт өвчний вакцин нөөцөлсөн байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.
- Тайлант онд өмнөх оны аж ахуйн нэгжүүдэд олгох тарилгын хөлсний үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.
- Эздийн өмчийн өөрчлөлт данс нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалан өссөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 403,447.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 361,756.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас төрийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл болон нийгмийн даатгалын зардал болон бараа ажил үйлчилгээний зардлын өсөлтөөс шалтгаалан төсөв нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 94,177.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 478,267.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 475,767.8 сая төгрөгийн санхүүжилт олгож, 124,351.3 сая төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 370,956.2 мянган төгрөг буюу 77.97 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 124,351.3 сая төгрөгөөр дутуу зарцуулж, улсын төсөвт татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мян.төг/						
№	Хөтөлбөр	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70801-Мал аж ахуйг хөгжүүлэх	Бараа ажил үйлчилгээний зардал	86,481.4	63,298.1	23,183.3	73.2
2	70805- ХАА газар тариалан аж үйлдвэрийн бодлого	Үндсэн үйл ажиллагааны зардал	391,786.4	301,675.2	90,111.2	77.0
Нийт дүн			478,267.8	364,973.3	113,294.5	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 211,137.0 мянган төгрөгийн орлого мал эмнэлгийн тарилга үйлчилгээний хөлс 196,376.5 мянган төгрөг, улсын мал эмнэлгийн эрүүл ариун цэврийн төв лабораториос мялзан шүлхий бруцеллёзын мониторинг хийх зардлын санхүүжилт 5,898.2 мянган төгрөг, мал эмнэлгийн 100 жилийн томилолтын зардалд 1,692.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс мал эмнэлгийг урьдчилан сэргийлэх үзлэгийн шатахууны зардалд 1,674.5 мянган төгрөг, ТЖА-ийн цалин 5,567.7 мянган төгрөг тус тус олгосныг зориулалтын дагуу зарцуулж 1,878.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь тайлант онд худалдан авалт зохион байгуулаагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Платиниум прогресс аудит” ХХК-ийн аудитор Ж.Баяртуул гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Платиниум прогресс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 481,419.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,221.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 5,054.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгадагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5.Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Санхүүгийн тайлангийн аудитын ажил гүйцэтгэх гэрээ оройтож хийгдсэн тул завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	292.9	2	292.9	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	0	0	0	0	0
Нийт дүн	2	292.9	2	292.9	100

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,986.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 135.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 3,851.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгч ажиллаа.

5.1 Төлбөрийн акт

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэний нийгмийн даатгалын шитгэлийг суутгахдаа 40.5 мянган төгрөгийг илүү суутгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах"

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэсэн заалтыг зөрчсөн ба *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журмыг зөрчин илүү суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд албан хаагчийн ээлжийн амралтын тооцоолж олгохдоо 94.8 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021.12.06-ны өдрийн А/91 тоот тушаалыг "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1 дүгээр хавсралтын 3.4-т *"Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно"* гэсэн заалтыг зөрчсөн ба *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон ээлжийн амралтын цалинг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

5.3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Тайланд онд ЗГ-ын 2023.12.27-ны 52 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу 12 албан хаагчдад 12,840,000 төгрөгийн цалингийн урамшууллыг олгохдоо ажилласан цаг хугацаа болон ажлын үр дүнг харгалзалгүйгээр нийтэд нь хавтгайруулан олгосон байна. Тус урамшууллыг олгохдоо ажилласан цаг хугацааг харгалзуулан тооцоход 3,851,000 төгрөгийг хэмнэх боломжтой байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3-т *"сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх"* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах.

Дээрх зөвлөмжийн шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалыг албан хаагчаас илүү суутгасан байна.	1	40.5	1	40.5								
Ээлжийн амралтыг илүү олгосон	1	94.9	1	94.9								
Урамшуулал хавтгайруулан олгосон	1	3,851.0					1	3,851.0				
Дүн	3	3,986.4	2	135.4			1	3,851.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар №/24620306

Чойр

ТӨА-2024/10/НА-ӨТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон үйлчлэгчийн 7, 8 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийг "үндсэн ажилтан болох 01 код" гэсэн сонголтоор төлж даатгуулагчаас 40,506.00 (дөчин мянга таван зуун зургаан) төгрөгийг илүү суутгаж авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно," Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", "4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү суутгасан НДШ-ийн 40,506.00 (дөчин мянга таван зуун зургаан) төгрөгийг санхүүгийн тайланд өглөг үүсгэж, албан хаагчийн дансанд шилжүүлэх
2. Актын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹ ирүүлэхийг Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газрын төсвийн захирагч Ч.Отгонсүрэн, нягтлан бодогч Э.Нарангэрэл нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

"ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР

Ж.БАЯРТУУЛ

УСАО0559019049

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70543179.

008050066



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 13/24625306

Чойр

ТСА-2024/10/НА-СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Зооноз халдварт өвчин тандалтын асуудал хариуцсан мэргэжилтний ээлжийн амралтын тооцооллыг хийхдээ ажилласан хоног дутуу тооцсоноос 94,873.00 (Ерэн дөрвөн мянга найман зуун далан гурван) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021.12.06-ны өдрийн А/91 тоот тушаалыг "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1 дүгээр хавсралтын 3.4-т "Ээлжийн амралтын цалин тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно," Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", "4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон цалингийн 94,873.00 (Ерэн дөрвөн мянга найман зуун далан гурван) төгрөгийг Говьсүмбэр аймгийн Төрийн сан дахь **орон нутгийн орлогын "Төсөвт байгууллагын өөрийн орлого" 100220000954** тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Говьсүмбэр

¹ Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, Нутгийн удирдлагын ордон Утас: 70543179

аймгийн Мал эмнэлгийн газрын төсвийн захирагч Ч.Отгонсүрэн, нягтлан
бодогч Э.Нарангэрэл нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

“ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТОР


УСГА0055 9019049

Ж.БАЯРТУУЛ